



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 188

Улаанбаатар хот

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг
сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 405 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Зоос-Өртөө” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2017 оны 9 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралтад холбогдох тэмдэглэгээг ажлын 15 хоногийн дотор хийлгэхийг “Зоос-Өртөө” ХЗХ /Л.Цэрэнлхам/-нд үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН